



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

“Хөрс валют ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.2, 19.2.4, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөрс валют ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” гэсэн тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлүүлэхийг “Хөрс валют ББСБ” ХХК /С.Амарзаяа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000058